



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 08 сарын 3 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Г Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2010 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн ХЭГ/1553 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын Технологийн их сургуулийн 3 дугаар ангийн оюутан Отгонбаяр овогтой Урнаагийн суралцах хугацааны сүүлийн 2 жилийн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан/Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар/М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР

